



ТӨВ АЙМГИЙН УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

ТАБ-ын Дарга, тэргүүлэх аудитор

Л.Жаргалсайхан

И-мэйл: jargalsaihan_tuv@yahoo.com

Утас: 70272582

Факс: 01-272-22582

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Утас: 70273465

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273465 99018619

И-мэйл: maits2009@yahoo.com

Аймгийн аудитын газрын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

Цахим хуудас: www.audit.mn

2015 оны 4 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Угтаал сумын ЗДТГазрын төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд ТӨВ-2015/115/СТА-ТТЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Угтаал сумын ЗДТГазрын төсвийн 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Угтаал сумын ЗДТГазрын 2014 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 03 дүгээр сарын 25-наас 2015 оны 03 дүгээр сарын 28-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн аудитор Т.Майцэцэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Угтаал сумын ЗДТГазрын 2014 оны төсвийн санхүүгийн тайланг 2015 оны 04 дугаар сарын 03-нд ТАБ-т ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2015 оны 04 дүгээр сарын 05-наас 2015 оны 04 дүгээр сарын 07-ны хооронд гүйцэтгэсэн ба нягтлан бодогч тайлбар тодруулга өгөлгүйгээр 2015.04.11 –ний өдөр ирсэн тул аудитын тайланг 2015 оны 04 дугаар сарын 13-нд Төв аймгийн Угтаал сумын ЗДТГазрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Үндсэн хөрөнгөд элэгдэл тооцох тухай” журмыг 2014 оны 297 дугаар тогтоолоор хүчингүй болгосон байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дүгээр зүйлийн 1-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь

Тамгын газар байх бөгөөд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тус хуулийн 33 дүгээр зүйлд тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 6.2.-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагааг төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38-д “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэж заасны дагуу Төв аймгийн Угтаал сумын ЗДТГазрын дарга Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг сумын ИТХурлаас баталж аймгийн Төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хуулийн , НББ-ийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Угтаал сумын ЗДТГазрын төсвийн 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс Төв аймгийн Угтаал сумын ЗДТГазрын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын болон нарийвчилсан 11 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг болон аудит хийхэд шаардлагатай мэдээлэл, баримт материалыг ирүүлээгүй. Бүртгэлийн асcolous програм ашигладаг байна.

Төсвийн шууд захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төв аймгийн Угтаал сумын ЗДТГазрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан ба санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгыг бичиж ирүүлээгүй.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын ажлын төлөвлөгөө тайлан ирүүлээгүй. Иймд хөрөнгийн тооллого, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт зэрэг санхүүгийн механизмыг бүхэлд нь хянадаггүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төв аймгийн Угтаал сумын ЗДТГазрын Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 2014 онд ЗДТГазар батлагдсан төлөвлөгөөгөөр 212300.6 мянган төгрөг зарцуулахаас 205216.5 мянган төгрөгийг буюу 7084.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулж, төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 1556.9 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

ЗДТГазрын нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар 80972.7 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж зарцуулаагүй үлдэгдэл 2433.1 мянган төгрөгийг сумын орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлж авлага үүсгэсэн.

Баг нь орон нутгийн төсвөөс 30300.6 мянган төгрөгийн буюу 450.0 мянган төгрөгөөр дутуу санхүүжилт авч, урсгал зардалд 30136.5 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 164.1 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан 11 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төв аймгийн Угтаал сумын ЗДТГазрын төсвийн 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад цаг хугацааны хязгаардагдмал байдлаас шалтгаалан үндсэн цалингийн зардлыг дүнгээр тулган шалгасан ба санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

**Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг
шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн тайлангийн дүнг тооллогын бүртгэлтэй тулган шалгахад тооллого хийж, тооцоо бодоогүй, тооллогын бүртгэлийг нярав хөтөлсөн, тооллогын комисс гарын үсэг зурж баталгаажуулаагүй, байвал зохих дүнгээс 88456.1 мянган төгрөгөөр зөрүүтэй нь ашиглалтанд байгаа эд хөрөнгийг тооллогын бүртгэлд бүртгээгүйтэй холбоотой байна. Энэ нь ТБОНӨТХуулийн 72.4.4-д комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Тооллогын комисс нь 88456.1 мянган төгрөгийн хөрөнгийг зөрүүтэй тоолсон, тооллогын бүртгэл хөтөлж баталгаажуулаагүй тооллогын комиссын гишүүдэд арга хэмжээ тооцож ирүүлэх ба Хөрөнгийн тооллогыг үнэн зөв, чанартай явуулж, тооцоог бодож байх ба түүнд тавих хяналтыг сайжруулах албан шаардлага бичсэн.

2. ОНХСангаас хийгдсэн нийтийн эзэмшлийн талбай 30000.0 мянган төгрөг, хандиваар хийгдсэн хүүхэд залуучуудын талбай 20000.0 мянган төгрөгийг барилга байгууламж дансанд, 9 хөлт цагаан тугийг 5000.0 мянган төгрөгөөр тавилга эд хогшил дансанд бүртгэсэн байна. НББ-ийн тухай хуулийн 9.1. Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана. Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалын 4.16-д Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалын 4.16 –д заасны дагуу бараа материалыг үнэн зөв ангилан бүртгэж тайлагнаж зөрчлийг давтан гаргахгүй байх ба 55000.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэн зөв ангилан залруулж бүртгэх албан шаардлага бичсэн

3. Үндсэн хөрөнгийн элэгдэл өмнөх оны элэгдлээс 10744.2 мянган төгрөгөөр буурсан, түүх соёлын дурсгалт зүйлсд элэгдэл тооцоогүй, программ хангамжинд тооцсон элэгдэл зөрүүтэй зэрэг нь элэгдлийн зардлыг дахин хянах шаардлагатай байна.

Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалын Үндсэн хөрөнгийн элэгдлийн бүртгэл 4.35-д Элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ.

Шийдвэрлэсэн: 2014 оны Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг дахин тооцож зөрүүг залруулан тайлагнах зөвлөмж өгсөн

4. Мөнгөн хөрөнгийн журналд 1440.4 мянган төгрөгийн буцаж орсон орлогыг тусгаагүй, Бэлнээр авч зарцуулсан мөнгөний тооцоо хангалтгүй анхан шатны баримт дутуу кассын тайланг дутуу хагас гаргадаг, кассын бэлэн мөнгөний орлогын болон зарлагын баримт бичдэггүй, шагнал тэтгэмж аливаа зардлын 7869.2 мянган төгрөгийн зарцуулалтын болон гардуулалт хүлээн авсан хүний гарын үсэг зуруулдаггүй нийтлэг зөрчил байна. Нягтлан бодогч кассын тайланг няраваас хүлээн авахдаа хянаж шалгаж авдаггүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 4.1.2-д санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх; НББ-ийн тухай хуулийн 7.6-д Анхан шатны баримтын бүрдэлт, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, Сангийн сайдын 2012 оны 276-р тушаалын 1-р хавсралтаар батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын заалтыг хэрэгжүүлээгүй Засгийн газрын 2012 оны 205-р тогтоол Төрийн Сангийн үйл ажиллагааны журам 7.11-д Тухайн байгууллагын данснаас дараах тохиолдолд орлого бууруулах гүйлгээ хийхийг зөвшөөрнө 7.11.3, 7.11.4 –д заасан заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Буцсан гүйлгээг мөнгөн гүйлгээний журналд бүрэн тусгах ба бэлэн мөнгөний тайлан анхан шатны баримтын бүрдүүлэлтийг сайжруулах зөвлөмж өгсөн

5. Албан томилолтын хуудасгүй болон замын зардлын баримтгүй 871.0 мянган төгрөг олгосон нь НББ-ийн тухай хуулийн 7.6-д Анхан шатны баримтын бүрдэлт, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, Засгийн Газрын 1995 оны 218-р тогтоолын 3.12 заалт “Албан томилолтын зардлын тооцоог ирснээсээ хойш ажлын 5 өдөрт багтаан гүйцэтгэсэн ажлынхаа үр дүнг албан томилолт олгосон удирдах албан тушаалтанд танилцуулан томилолтын үнэмлэх дээрээ гарын үсэг зуруулна” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна

Шийдвэрлэсэн: Албан томилолтын хуудас байхгүй, замын зардлын баримтгүйгээр олгосон 871.0 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

6. Тайлант оны эцсээр шинээр 3833.1 мянган төгрөгийн авлага, 188.1 мянган төгрөгийн ХАОАТ-ын өр шинээр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Тайлант онд шинээр үүссэн 4021.2 мянган төгрөгийн өр авлагыг барагдуулах ба өр авлага үүсгэхгүй ажиллах талаар албан шаардлага бичив.

7. Зардал хооронд шилжүүлэх хүсэлт зөвшөөрөлгүйгээр 584.4 мянган төгрөгийг зардал хооронд шилжүүлэн зарцуулсан, 416.7 мянган төгрөгийн шатахууны зардлыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бичсэн нь Сангийн сайдын 2013 оны 73-р тушаалыг болон Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалын 1-р хавсралтын 4.21 дэх заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: 1001.1 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох Сангийн сайдын 2013 оны 73-р тушаалыг болон Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалын 1-р хавсралтын 4.21 дэх заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн.

8. Санхүүгийн тайланг хугацаа хоцруулсан, тодруулга тайлан ирүүлээгүй, бараа материал, үндсэн хөрөнгийн тайлан, ЗДТГазрын нэмэлт санхүүжилтийн харилцах дансны баримтыг аудитын явцад авчирч шалгуулаагүй байна. Төсвийн тухай хуулийн 8.9.3.сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны төсвийн ... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, ... аудит хийсэн тайланг нийтэд мэдээлэх; 16.5.7.байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах, Төрийн аудитын тухай хуулийн 21.1. Төрийн аудитын байгууллага, түүний ажилтнууд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах аливаа мэдээллийг бүрэн хэмжээгээр, чөлөөтэй, шуурхай авах эрхтэй. Энэ хуулийн 15.1-д заасан байгууллага, албан тушаалтан төрийн аудитын байгууллагаас шаардсан мэдээллийг хугацаанд нь саадгүй гаргаж өгөх үүрэгтэй гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хуулийг чанд сахиж, санхүүгийн тайланг хуулийн хугацаанд үнэн зөв тайлагнаж байх зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад алдаа залруулаагүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны шалтгаанаас аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй хөрөнгийн тооллогыг ажиглах, үндсэн хөрөнгөөс түүвэрлэн хяналтын тооллого хийх ба цалингийн тооцооллыг давтан шалгах ба нэмэлт санхүүжилтийн харилцах дансны баримт, бараа материал үндсэн хөрөнгийн тайлагналын асуудлыг завсрын аудитаар нөхөн шалгахаар тогтоов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Угтаал сумын ЗДТГазрын төсвийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 169403.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 871.0 мянган

төгрөгийн төлбөрийн акт, 147477.3 мянган төгрөгийн албан шаардлага, 21054.9 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох өвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төв аймгийн Угтаал сумын ЗДТГазрын төсвийн 2013 оны санхүүгийн тайланд Аудитаас өгсөн зөвлөмжийн дагуу дотоод хяналт шалгалтын комисс байгуулан ажиллаж байгаа гэсэн боловч дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:
Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Төв аймгийн Угтаал сумын ЗДТГазрын төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 9 хуудас, байгууллагын санал .. хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

Т.МАЙЦЭЦЭГ